


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-22 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 8 аймагт **1321** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1321 тохиолдлын 94% /1243/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /78/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /2/, Баянхонгор /1/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **367** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **22** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.05.25 – 05.31)

2025 оны эпидемиологийн 22 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын **1** тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 50 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 97 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-22 дугаар долоо хоногт нийт 576** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


332Эмнэлгийн
тусламж авч буцсан**244**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
46%Эмэгтэй
54%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 22 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **18** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 33 хувиар буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 55 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 22 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	2	6	8
2	Эмийн хордлого	6	4	10
Нийт		8	10	18

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санамсаргүйгээр** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд шалтгаанаар авч үзвэл харшил, нойрны эм болон будаг шингэлэгч, галын хор зэрэг ахуйн болон цэвэрлэгээний зориулалттай бүтээгдэхүүнүүдэд хордсон байна. **Санаатайгаар** өртсөн тохиолдлуудыг авч үзвэл 28-70 насны хүмүүс байгаа бөгөөд олон тооны эм хольж уусан байна.

-ооо-